



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2007 оны 10 сарын 12 өдөр

Дугаар 370

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах, тушаалд
өөрчлөлт оруулах тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 52 дугаар тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах журам", Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт Сургалтын төрийн сангийн зээлээр өөрийн захиалгаар хүн суралцуулах эрх бүхий байгууллагуудын санал, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, "МИАТ" ХК хооронд 2006 оны 12 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан Хамтран ажиллах гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Лувсанжав овогтой Жавхланг Улсын Их Хурлын Тамгын газрын захиалгаар АНУ-ын Pacific States их сургуулийн магистрантурт мэдээллийн системийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Батмөнх овогтой Нарангэрэлийг Монголбанкны захиалгаар БНСУ-ын Гёнги их сургуулийн магистрантурт банк, санхүүгийн чиглэлээр 1 жилийн хугацаагаар тус тус 2007-2008 оны хичээлийн жилээс Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

2. Гансүх овогтой Баатарцогт, Цэрэнжав овогтой Ууганбаяр, Батмөнх овогтой Өнөбат, Энхтуяа овогтой Энхбаяр, Ямааранз овогтой Сайнбаяр, Баярсайхан овогтой Эрдэнэ-Уул, Баатаржав овогтой Булган, Бямбаа овогтой Очирбат, Баасанжав овогтой Гантулга, Лундаажанцан овогтой Баяржаргал нарыг АНУ-ын Flight Sierra академийн мэргэжлийн нисгэгчийн сургалтад 2 жилийн хугацаагаар 2007-2008 оны хичээлийн жилээс Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

3. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2006 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 296 дугаар тушаалын Мурат овогтой Мунаратай холбогдолтой хэсгийн "АНУ-ын Shenandoah их сургууль" гэснийг "АНУ-ын Maryland их сургууль" гэж өөрчилсүгэй.

4. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-

д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.



[Handwritten signature]

Ө.ЭНХТҮВШИН